



*ШШГЕГ-ын харъяа
хорих 405 дугаар ангийн
гүйцэтгэх ажил, харуул
хамгаалалт эрхэлсэн дэд
дарга, ахмад
Э.Бямбадорж*

ГЯНДАНД ЯЛ ЭДЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ ЖУРАМ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Нэг. Гяндангийн талаарх ойлголт, түүхэн уламжлал

“Гяндан” хэмээх ойлголт нь эртнээс улс орнуудын ял эдлүүлэх системд хорих ял эдлүүлэх, цагдан хорих чиг үүргийн аль алиныг гүйцэтгэж байсан хатуу хяналт, нөхцөл бүхий хорих байр гэсэн ойлголтоор хэрэглэгдэж ирсэн байдаг ба энэ үгийг Монголчууд ерөнхийд нь шорон гэсэн утгаар ойлгох нь түгээмэл байдаг.

Гянданд ял эдлүүлж байсан талаарх түүхэн судалгаа, тэмдэглэл тун ховор байдаг ба нэлээн сүүлд буюу Ардын Засгаас 1921 оны 7 дугаар сарын эцсээр Монголын Автономитын үеийн хууль цаазын анхны мэргэжилтэн Ц.Гүрсэдээр удирдуулсан комисс томилж, Нийслэл хүрээний Их гяндан, Их шавийн гяндан, Баруун хүрээний гяндан зэргийг шалгаж үзэхэд Их шавийн гяндангийн тасалгаа бүрт 20 орчим хүнтэй гадуураа 5 алд өндөр шовх үзүүр бүхий хашаатай, дотор зай нь өндрөөрөө алд хүрэхгүй зайтай, үзэгдэх гэгээгүй, гяндангийн нэг тасалгаанд хулгайн хэргээр шийтгэгдсэн 80 жингийн гинжтэй хүн 2, мөхлөгтэй 1 хүн байжээ. Эдгээрийг суллан тавьж бусад зохимжгүй гяндангийн байруудыг бүр мөсөн устгаж гагцхүү хүний

бие махбодь эрүүл мэндэд онцын хоргүй болгон Их гянданг хэвээр үлдээж байжээ¹⁵.

Ийнхүү Ардын түр засгийн газраас Гяндан хорооны талаар авч хэрэгжүүлсэн хувьсгалт арга хэмжээний эхнийх нь Манжийн хаант монголын улсын үеэс шинэ Монгол улсын үе хүртэл он улиран хадгалагдаж ирсэн хуучин гянданг устган сайжруулж шинэчлэхэд чиглэгдэж байв.

Гэхдээ Монгол оронд 1921 онд ялсан Ардын хувьсгалын үеийн “Гяндан салаа”-г одоогийн гяндан гэх ойлголттой шууд харьцуулан авч үзэх боломжгүй юм. Учир нь тухайн үед гяндан гэдэг үг бүхэлдээ хорих ял эдлүүлэх, түүнчлэн урьдчилан хорих байгууллага гэдэг утгаар хэрэглэгдэж байсан гэж үзэж болох талтай. Өөрөөр хэлбэл тэр үеийн хорих ял эдлэгсдийг одоогийнх шиг хорих ялын дэглэмийн хувьд нарийвчлан ялгаж байгаагүй юм¹⁶.

Гянданг чухам хэдэн онд байгуулсан тухай асуудлыг авч үзэхдээ: Монгол улсын хууль тогтоомжинд хэдийгээс эхлэн гэмт хэрэг үйлдэж шийтгэгдсэн этгээдийн ялыг гянданд эдлүүлэхээр заасан үетэй холбон авч үзэх учиртай. Шинэ үеийн Монгол улсын хорих ял эдлүүлэх тогтолцоонд гянданд ял эдлүүлэх чиглэл нь 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулинд анх тусгагдсан бөгөөд тухайн үеийн ЗСБНХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн агуулгаас хуулбарлагдан орж ирсэн гэж судлаачид үздэг.

Монгол улсын Хорих ял эдлүүлэх байгууллага, ялангуяа гяндангийн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжилтөнд шинээр орж ирсэн нэг зүйл бол

¹⁵ Б.Даштэвэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй-1 УБ. 2003, 80 дахь тал

¹⁶ А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал 1921-2011 УБ. 2011, 79 дэх тал



“Хугацаагүй хорих тусгай салбар” юм. 1993 онд батлагдсан Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол улсын хуулинд Хорих байгууллагын тогтолцоонд гяндан, хугацаагүй хорих тусгай салбарыг оруулан хуульчилсан юм. Энэ хуульд гяндан, хугацаагүй хорих тусгай салбарт хоригдож буй ялтнуудад холбогдох нөхцөл журам, зардал зэргийг нарийвчлан зааж өгсөн байна.

Мөн 1993 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд: “Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хугацаагүй хорих ялаар солино” гэсэн эрх зүйн шинэ институт бий болсон билээ. Харин энэ төрлийн ял эдлүүлэх нөхцөл журмыг 1996 онд батлагдсан Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулинд “Хугацаагүй хорих ял эдлэгдэгсдэд эхний 5 жилийг гяндангийн чанга, үлдэх хугацааг онцгой дэглэмтэй хорих ангид эдлээд нийгэмд аюулгүй болсон үедээ суллагдаж болох” талаар хуульчилж байжээ.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын эхний ээлжинд хамаарагдах дээр дурдсан хуулиудад үг үсгээс эхлээд, үзэл бодлын зөрөөтэй томьёолол, нэг нь нөгөөдөө харшилсан төдийгүй, эрх зүйн харилцаанд оролцогч субъектүүдийн эдлэх эрх, хүлээх үүрэг харилцан адилгүй тусгагдсан, зарим тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг илтээр зөрчсөн заалт олон байсан. Эдгээрийг хууль тогтоогчид нэг мөр болгон жигдлэх, төрийн ялын бодлого, төрөлд зарим өөрчлөлт оруулах зорилт тавьж шийдвэрлэсний жишээ бол 2002 онд батлагдсан Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль,

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд юм.

Хууль тогтоогчид Монгол Улсын Эрүүгийн хуулийн хугацаагүй хорих тухай ойлголтыг хасч найруулснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад яг энэ нэр, агуулгаар нь ял эдлүүлэх боломжгүй болж, шинэ нөхцөл байдал үүссэн ба Монгол Улсын Эрүүгийн хуулийн 53.3 зүйлд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар гянданд хорих ялаар солих болсон байна.

Энэ 2012 оны 11-р сарын байдлаар гэхэд л шүүхийн практикт онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт үйлдлийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан гянданд ял эдлүүлэхээр тогтоож байгаа ба ял эдлүүлэх хамгийн хатуу хяналт, цээрлэл, хязгаарлалттай нөхцөл хэмээн ойлгож болохоор байна. Тэгвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад зааснаар бол гяндан нь хорих анги биш, ял эдлүүлэх дэглэмийн төрөл ч биш ойлгогдож хэрэглэгдсээр өнөөдрийг хүрчээ.

Хоёр. Гянданд ял эдлүүлж буй өнөөгийн нөхцөл байдал.

Гянданд ял эдлэгсдийг ял эдэлж буй байдлаар нь ялган авч үзвэл:

1. Цаазаар авах ял шийтгэгдсэн этгээдийн амийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс уучилсан тохиолдлоор 30



жилийн хорих ялыг гянданд эдлэхээр шийтгэгдсэн ялтнууд,

2. Онцгой дэглэмтэй хорих ангид ял эдлэхээр шүүхээс шийтгэгдсэн боловч удаа дараа зөрчил гаргаж шүүхээс тодорхой хугацаагаар гянданд ял эдлүүлэхээр хорих ялын дэглэм дээшилж шийтгэгдсэн ялтнууд,

3. Шүүхийн шийтгэх тогтоолд ялын тодорхой хувийг гянданд ял эдлүүлэхээр анх шийтгэгдсэн ялтнууд гэж ангилан үзэж болно.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн зарим заалтуудад ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ял оногдуулах тодорхой тохиолдлуудыг заан тодорхойлсон бөгөөд энэ нь ч хэрэгжиж байна.

Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 оны 6-р сараас эхлэн цаазаар авах ялыг цаашид гүйцэтгэхгүй байх талаар мэдэгдэл хийж, УИХ-аас 2012.01.05-ны өдөр “Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактын цаазар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II дугаар протоколд нэгдэн орох тухай хууль”-ийг баталснаар дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагын өмнө Монгол улс цаазаар авах ялыг халахтай холбоотой шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээх эрх зүйн үндэс баталгаажсан юм.

Эрдэмтэн судлаачдын зүгээс ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг онцгой ял хэмээн тодорхойлж ойлгодог ба нэгэнт цаазаар авах ялыг халах тохиолдолд сольж хэрэглэх ял нь эрүүгийн эрх зүйн зарчимд нийцсэн төдийгүй улс орны эрүүгийн ялын бодлогод сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй шинжийг агуулсан байх нь зүйн хэрэг юм.

Өөрөөр хэлбэл тухайн гэмт үйлдлийн нийгмийн хор аюул, шинж чанарт тохирсон байхын зэрэгцээ эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахуйц байх ёстой юм. Цаазаар авах ялыг халсан болохоор мэдээж хэрэг гяндангийн ялтны тоо эрс өсөх, жил ирэх бүр ялтныг байршуулах өрөөний багтаамж, хорих ангийн даац болон аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөл байдал хүндэрч байгаа нь сүүлийн ганц жилд хийсэн харьцуулсан судалгаанаас харагдаж байна. Жишээлвэл 1994 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “цаазаар авах ял”-аар шийтгүүлсэн нийт 34 ялтны амийг уучлан 30 жилийн хугацаагаар гянданд хорих ялаар сольж ял эдлүүлж байна. Эдгээр 34 ялтаас өнөөдрийн байдлаар буюу 1994 оноос хойшхи 19 жилийн хугацаанд: Эрүүл мэндийн шалтгаанаар нас барсан 6, амиа хорлосон 2, шүүхээр дэглэм буурсан 2, нийт 10 ялтан хасагдсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар амь уучлагдсан ялтны тоог он дарааллаар жагсаавал: 1995 онд 1, 1996 онд 1, 2000 онд 1, 2006 онд 1, 2009 онд 6, 2010 онд 10, 2011 онд 5, 2012 оны эхний 8 сарын байдлаар 9 ялтан тус тус амь уучлагдсан байна. Үүнээс харахад 1995-2009 оныг хүртэлх 14 жилийн хугацаанд 10 ялтны амийг уучилсан байхад, Монгол Улс цаазаар авах ялаас түдгэлзсэн, татгалзсан үе буюу 2010 оноос хойш өнөөдрийг хүртэлх 2 жилийн хугацаанд 24 ялтны амийг уучилсан тоон үзүүлэлт гарч байна¹⁷.

Нэгэнтээ Монгол улс хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон, дэлхий нийттэй хөл нийлүүлэн, хүний эрхийг өндөрт өргөх бодлогын дагуу цаазаар

¹⁷ ШШГЕГ-ын харьяа хорих 405 дугаар ангийн нэгдсэн танилцуулга УБ 2012



авах ялыг халсан нь сайшаалтай боловч онц хүнд гэмт хэрэг үйлдэж, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон, цаазаар авах ялаар шийтгүүлж амь уучлагдсан ялтнуудын тоо жил ирэх бүр нэмэгдэж энэ байдал нь хорих ял эдлүүлэх нөхцөл байдал, гяндангийн аюулгүй байдалд онцгой хүндрэл учруулж байгааг анхаарах шаардлагатай байгаа юм.

Ялтныг гянданд байршуулахын тухайд Цаазаар авах ял шийтгэгдэж амь уучлагдсан, 30 жилийн хорих ялыг гянданд эдлэхээр шийтгэгдсэн ялтнууд болон онцгой дэглэмтэй хорих ангиас дэглэм дээшилж шийтгэгдсэн ялтнууд, шүүхийн шийтгэх тогтоолд ялын тодорхой хувийг гянданд ял эдлүүлэхээр анх шийтгэгдсэн нийт 94 ялтныг, өнөөдрийн байдлаар бүрэн ашиглагдаж байгаа 66 хорих өрөөнд 1-2-оор нь байршуулж байна. /хавсралт судалгаа/ Гянданд ял эдэлж буй 94 ялтан нь Монгол улсын хэмжээнд нийт ял эдлэгсдийн тоотой харьцуулахад өчүүхэн бага хувийг эзэлж байгаа хэдий ч гяндангийн өөрийнх нь ачаалал, нөхцөл байдлын хувьд түүхэндээ хамгийн олон ялтан ял эдлүүлж байгаа үзүүлэлт бөгөөд энэ тоо жил ирэх бүр нэмэгдэх нь гарцаагүй байгаа нь анхаарал татаж байгаа юм. Гянданд ял эдлэгсдийн тоо эрс нэмэгдэн тэднийг нийгмээс тусгаарлах байр хүрэлцээгүйгээс онц аюултай гэмт хэрэгтнүүд нэг газар төвлөрч үүнээс үүдэн ялтнуудаас гаргаж буй зөрчлийн шинжтэй үйлдэл, яриа өгүүллүүд нь өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад эрс өсч байна. Энэ байдал нь тэнд ажиллаж буй төрийн албан хаагчдын аюулгүй байдал болон цаашлаад нийгэм, иргэдийн амгалан тайван байдал шууд хөндөгдсөн асуудал болоод байгаа билээ. Иймд нэгэнтээ гянданд ял эдлэгсдийн тоо, нэмэгдэж улам хүндрэх нь

ойлгомжтой болоод байна. Иймд тэнд хоригдогсдын ял эдлүүлэх нөхцөл байдал, аюулгүй байдлыг хангах, бусад хяналт, үйлчилгээг хэрхэн зөв зохион байгуулахал анхаарах нь чухал юм.

Гянданд ял эдлүүлэх нөхцөл, журмын талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн ганцхан зүйлд /109 дүгээр зүйл/ товч байдлаар тусгаж өгсөн нь цаашид гяндангийн үйл ажиллагааг бүрэн дүүрэн зохицуулахад зарим талаар учир дутагдалтай байна. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 109.1-д: “Гяндангийн ялтныг ганцаарчилсан тасалгаанд хорих бөгөөд шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөж, гяндангийн ялтныг **нийтийн тасалгаанд хорьж болно**” гэсэн байхад “Хорих ангийн дотоод журам”-ын 4.6.2-т “**Нэг өрөөнд хоёроос илүүгүй** ялтныг хорих ба шаардлагатай гэж үзвэл хорих ангийн дарга прокурортой зөвшилцөн ганцаарчлан байрлуулж болно” гэжээ. Энэ хоёр заалтыг харьцуулан үзэхэд ойлгомж муутайгаас гадна **нийтийн тасалгаа** гэсэн нэр томъёонд 2 ялтныг хамт байрлуулан хорих эсэх нь тодорхойгүй байна.

Тухайн ялтны хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлогоос шалтгаалан ганцаарчилсан болон 4 хүртэлх тооны хоригдогчийг хамтад нь хорих өрөөний системд ял эдлүүлэхээр тооцох нь илүү үр дүнтэй байх боломжтой юм. Ингэвэл хорих ял эдлүүлэх ажиллагааг ялтны хувийн болон үйлдсэн гэмт хэргийн байдлыг харгалзан зохион байгуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ хяналт хамгаалалтын болон нийгэмшүүлэх хөдөлмөрлүүлэх, бие даан ухамсарлуулах арга хэмжээ үр дүнтэй



ялгамжтай явагдах боломж нээгдэнэ гэж судлаач, докторант Ц.Очгэрэл “Бүх насаар нь хорих ял буюу түүнийг эдлүүлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт илтгэлдээ дурьдсан байгаатай санал нэг байна.

Мөн “Хорих ангийн дотоод журам”-ын 4.6.1-т “Хорих өрөө нь ялтанд хяналт тавих боломжтой торлосон хаалгатай, хаалга нь хязгаарлагчтай, хагас онгойхоор зохицуулагдсан байхаас гадна байнгын цоожтой байх” гэсэн заалт нь цаашид гянданд хоригдогсдын тоо нэмэгдэж ял эдлүүлэх нөхцөл байдал, аюулгүй байдлыг хангах, хоригдогчид өөр хоорондоо мэдээлэл солилцох, чөлөөтэй харилцах байдлыг таслан зогсоох болон бусад хяналт, үйлчилгээг зохион байгуулахад хүндрэл учирч болзошгүй байдлыг харгалзан хорих өрөөний торон хаалганы гадуур давхар хамгаалалтын битүү хаалга гаргаж зориулалтын нээлхийгээр хянаж байх, хорих өрөөн дотроос цонхонд хүрэх хөдөлгөөнийг хязгаарласан торон хаалт хийх шаардлага тавигдаж байгаа юм.

Үүнээс гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 335 дугаар зүйлд “гянданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ”, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1-т “Хорих ангийн дэг журмыг чанд сахиж хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна....-Хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө тэнсэн суллах, дэглэм

бууруулах, гянданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорих ялаар солих тухай санал гаргах” гэсэн заалт нь яаж ч ойлгосон гяндангийн ялтанд хамаарах асуудал хөндөгдсөн байна. Гэтэл энэ зүйл заалтууд нь амь уучлагдаж 30 жил хоригдож байгаа ялтнуудад үйлчилэх эсэх нь тодорхой бус байна.

Гяндангийн түүхэнд амь уучлагдаж 30 жил гянданд хоригдсон ялтнуудаас 2 ялтныг дэглэм бууруулсан тохиолдол байдаг ба өнөө үед тухайн үед хэрэглэж байсан хууль, эрх зүйн зохицуулалт нь хэвээрээ байгаа атал прокурорын байгууллагаас “Ялтан оногдуулсан хорих ялын тодорхой хувийг эдэлсэн, засрал хүмүүжлээ зан байдлаараа харуулж гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн эсэх нь тодорхой бус байна” гэсэн шалтгаанаар гянданд 30 жил хорих ял эдлэхээр шийтгэгдсэн ялтнуудыг /өнөөдрийн байдлаар 2 ялтан 18 жил гянданд хоригдоод байгаа болно/ дэглэм бууруулахаас татгалзсаар байгаа билээ.

Гянданд 30 жилийн ял эдлэхээр шийтгэгдсэн ялтныг дэглэм бууруулах асуудлыг нэг мөр шийдвэрлэснээр, цаазаар авах ялыг халж гянданд 30 жилийг өнгөрүүлэх ялтнуудын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа энэ цаг үед тухайн ялтанд тодорхой ял эдлэх хугацааны дараа өөрийн зан төлөв, хандлагын хувьд болон хууль журамд нийцүүлэн биеэ авч явах байдал зэргээрээ эерэгээр өөрчлөгдөх боломж олгох нь эрүүгийн хариушлагын зорилгыг хангах нөхцлийг бүрдүүлэхээс гадна хүнлэг ёсыг сахих, хүний эрхийг дээдлэх зарчимд нийцсэн явдал болох юм.



Энэ бүгдээс дүгнэж үзэхэд: Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, нийгмээс тусгаарлах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн өмнө хүлээсэн үүргээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэвийн гүйцэтгэж байгаа боловч цаазаар авах онцгой ялыг халж, онц аюултай гэмт хэрэгтнүүд жил бүр нэмэгдэж нэг газар төвлөрөх асуудал, бэрхшээл зайлшгүй тулгарч байгаа тул дээрх судалгаа, дүгнэлттэй холбогдуулан дараахь саналыг дэвшүүлж байна.


1. Хорих өрөөний стандарт, хамгаалалтын техник хэрэгслийн байгууламжийг тусгайлан тогтоож өгөх, хорих нөхцөл ижил гадаадын аль нэг орны туршлагаас судлах, тохирохыг нь нэвтрүүлэх
2. Хорих өрөөнд ганцаарчлан хорих ба тодорхой хугацааны ялыг эдлэсний дараа боломжтой бол ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх
3. Эмнэлгийн бүхий л төрлийн тусламж үйлчилгээ болон сэтгэл зүй, зан үйлийн арга хэмжээ, хууль зүйн туслалцаа зэргийг зөвхөн хорих байранд үзүүлэхээр зохицуулах
4. Гяндангийн харуул хамгаалалтанд ашиглаж байгаа техник хэрэгслийг шинэчлэх, харуул хамгаалалтын албан хаагчийг аль болох ялтанд зайнаас хяналт тавих механизмыг бүрдүүлэх
5. Гяндангийн нөхцлийг дэглэмийн нэг төрөл болгон Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хууль оруулах, "Гяндангийн дотоод журам" гарган дээрх бодлого чиглэлд нийцүүлэн баталж мөрдүүлэх

6. Гяндангийн нөхцөлд тогтоосон цэгт ялтан, албан хаагчийн аюулгүй байдлыг хангах шаардлагад нийцсэн хөдөлмөр эрхлүүлэх зэрэг болно.



ГЯНДАНГИЙН ЯЛТНААС ГАРГАСАН ЗӨРЧИЙН СУДАЛГАА



Гяндангийн ялтан М.Энэрэлбаатар, Х.Ганзориг нар оргохоор бэлтгэсэн.



Зөрчил гаргасан ялтны тоо




ЯЛТНЫ СУДАЛГАА /ГЯНДАН-94/

Удал дараа	1 удаа	2 удаа	3 удаа	4 удаа	5 удаа	6 ба түүнээс дээш
Алх удаа	42	12	11	12	6	11

Дэглэм дээшилж ирсэн	20
Амь үүсчлөгдсөн 30 жилийн гяндан	34
Хорих ялын тодорхой хувиыг гянданд чөлөөтөр шийтгүүлсэн	40

Дэглэм давтан



Шүүхээс онц аюултай гэмт хэрэгтэйгээр тооцсон 17

Гянданд ял эдлэхээр иргэсдийн судалгаа

Он	Нийт ялтны тоо			Иргэдийн судалгаа			Шүүхээс онц аюултай гэмт хэрэгтэйгээр тооцсон		
	Гяндан			Дэглэм дээшилж ирсэн			Шүүхээс онц аюултай гэмт хэрэгтэйгээр тооцсон		
	Гяндан	30 жил	бүтэц	гяндан	30 жил	гяндан	Шүүхээс онц аюултай гэмт хэрэгтэйгээр тооцсон	Гяндангийн дуусч дэглэмийн ангид шилжсэн	хугацаа зохиох хорих
2006	46	7	53	14	1	1	16	26	
2007	53	6	59	26	1	3	30	21	
2008	47	6	49	24			24	34	
2009	29	10	39	13	6	5	24	30	
2010	31	19	50	11	10	4	25	9	3
2011	48	24	72	18	5	6	29		6
2012.08.22-ны байдлаар	60	34	94	12	9	6	27		9

Дээрх судалгаанаас харахад гянданд ял эдлэх ялтны тоо тогтмол нэмэгдэж байна. Жилд дунджаар 15-20 ялтан шинээр ял эдлэхээр ирнэ гэж тооцвол 10 жилд 150-200 ялтан гянданд шинээр ял эдлэхээр ирнэ гэсэн урьдчилсан тооцоо гарч байна.